



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/173

Мандагговь

“Эс Жи Эм” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А/151 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Замын гэрэлтүүлгийн засварын материал”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Эс Жи Эм” ХХК-тай 38,225,000 (гучин найман сая хоёр зуун хорин таван мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Замын гэрэлтүүлгийн засварын материал” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Эс Жи Эм” ХХК-ийн захирал (С.Лхагва-Оргил)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хот тохижуулах газрын дарга (А.Анхбаяр), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



ЦЭРДЭНЭСҮРЭН

482060704